**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

# Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ОРА-2022/19/НА-СТА-ТШЗ**

---


Цахим хуудас:
www.audit.mn
Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Б.Азжаргал
Утас: 70350757 Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn


---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1.Санал дүгнэлт ....................................................................................................................2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.............................................................4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..........................................................................4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .......................................................................5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..................................................8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан...............................................................................9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .......................................................................11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ...........................................................12
3. Аудитын тайлан ..................................................................................................................12
3.1 Ерөнхий зүйл ......................................................................................................................13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....................................................................13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .........................................................................14
3.4 Материаллаг байдал ...........................................................................................................14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ......................................................................................14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....................................................................15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг..........................................................14
3.8 Аудитын гол асуудал ..........................................................................................................16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ...................16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт..........................................................................17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт...........................................................................................17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал..............................................................................18
4. Аудитын илрүүлэлт...............................................................................................................18
4.1 Залруулсан алдаа ..........................................................................................................18
4.4 Зөвлөмж ..........................................................................................................................18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........................................................................19

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## АУДИТЫН САНАЛ ДҮГ

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.24 № 13

танай ______________-ны № ______________-т

ОРХОН АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ДАРГА М.АРИУНБОЛД ТАНАА

**Аудитын санал дүгнэлт**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

**НЭЛТ**

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 127,480,851.11 | 271,145,634.59 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 4,826,147.01 | 992,670.31 |
| 311 | Кассанд байгаа бэлэн мөнгө | 47,808.00 | - |
| 31110 | Төгрөг | 47,808.00 | - |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 4,778,339.01 | 992,670.31 |
| 3121 | Төгрөг | 4,778,339.01 | 992,670.31 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 4,778,339.01 | 992,670.31 |
| 33 | АВЛАГА | 8,400.00 | 132,750,000.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 8,400.00 | - |
| 335 | Бусад авлага | - | 132,750,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 132,750,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 122,646,304.10 | 137,402,964.28 |
| 351 | Түүхий эд материал | 53,848,067.50 | 48,632,865.70 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 50,895,954.00 | 47,713,911.00 |
| 35130 | Эм боох материал | 2,952,113.50 | 918,954.70 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 12,876,056.20 | 14,621,153.38 |
| 354 | Хангамжийн материал | 38,747,180.40 | 55,523,945.20 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 700,000.00 | 700,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 27,343,650.40 | 29,967,838.20 |
| 35450 | Барилгын засварын материал | 7,517,100.00 | 6,310,100.00 |
| 35460 | Хүнсний материал | 3,056,430.00 | 18,546,007.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 130,000.00 | - |
| 35600 | Мал амьтад | 17,175,000.00 | 18,625,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 4,123,558,667.12 | 4,071,528,591.49 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 4,123,558,667.12 | 4,071,528,591.49 |
| 392 | Биет хөрөнгө | 2,988,648,667.12 | 2,933,850,674.86 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,015,259,248.67 | 3,015,259,248.67 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (178,466,570.17) | (269,598,544.21) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 239,103,835.00 | 239,103,835.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (202,099,027.79) | (178,924,668.10) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 253,224,090.92 | 269,488,990.92 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (166,777,853.65) | (177,282,629.14) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 46,405,560.00 | 57,318,010.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (33,290,615.86) | (36,803,568.28) |
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | 15,290,000.00 | 15,290,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 10,000,000.00 | 10,000,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (10,000,000.00) | (10,000,000.00) |
| 393 | Биет бус хөрөнгө | 1,134,910,000.00 | 1,137,677,916.63 |
| 39301 | Програм хангамж | 6,417,692.31 | 6,417,692.31 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (6,417,692.31) | (3,649,775.68) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,134,910,000.00 | 1,134,910,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 4,251,039,518.23 | 4,342,674,226.08 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 4,825,643.64 | 154,892,670.31 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 4,825,643.64 | 154,892,670.31 |
| 413 | Өглөг | 4,825,643.64 | 154,892,670.31 |
| 4136 | Бусад өглөг | 4,825,643.64 | 154,892,670.31 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 153,900,000.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 4,825,643.64 | 992,670.31 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 4,246,213,874.59 | 4,187,781,555.77 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 4,246,213,874.59 | 4,187,781,555.77 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,375,985,407.34 | 1,375,985,407.34 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,375,985,407.34 | 1,375,985,407.34 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 971,475,592.40 | 913,043,273.58 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,031,371,489.96 | 971,475,592.40 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (59,895,897.56) | (58,432,318.82) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,898,752,874.85 | 1,898,752,874.85 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 4,251,039,518.23 | 4,342,674,226.08 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,881,554,228.50 | 1,711,814,939.70 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 290,842,528.50 | 329,194,036.70 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 290,842,528.50 | 329,194,036.70 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 290,842,528.50 | 329,194,036.70 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 230,026,200.00 | 154,632,500.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 60,816,328.50 | 174,561,536.70 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,590,711,700.00 | 1,382,620,903.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,384,115,700.00 | 1,360,223,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,384,115,700.00 | 1,360,223,400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 206,596,000.00 | 22,397,503.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,696,000.00 | 4,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 15,000,000.00 | 18,397,503.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 187,900,000.00 | |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,941,450,126.06 | 1,760,215,258.52 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,941,450,126.06 | 1,760,215,258.52 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,895,783,786.73 | 1,737,007,705.61 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 940,052,800.00 | 951,100,944.65 |
| 210101 | Үндсэн цалин | 601,629,800.00 | 611,253,300.00 |
| 210102 | Нэмэгдэл | 321,507,800.00 | 331,566,444.65 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,515,200.00 | 5,065,200.00 |
| 210104 | Урамшуулал | 1,500,000.00 | 3,216,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 7,900,000.00 | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 18,906,460.67 | 20,104,348.44 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,906,460.67 | 20,104,348.44 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 139,012,604.00 | 141,345,470.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 45,150,464.00 | 48,117,690.33 |

| | | | |
|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 45,971,340.00 | 51,078,579.67 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 47,890,800.00 | 42,149,200.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 348,794,763.00 | 152,245,287.82 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,128,650.00 | 6,492,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 27,585,900.00 | 27,514,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,966,400.00 | 2,588,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 147,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,908,000.00 | 5,442,410.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 311,465,813.00 | 109,810,277.82 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 740,000.00 | 250,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 234,094,136.26 | 204,592,065.50 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 6,260,790.00 | 8,599,758.80 |
| 210502 | Хоол, хүнс | 213,771,287.16 | 176,689,723.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 14,062,059.10 | 19,302,583.70 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 46,596,871.77 | 89,686,946.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,034,400.00 | 2,763,060.00 |
| 210602 | Тавилга | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 482,000.00 | 482,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 43,080,471.77 | 86,441,886.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 379,000.00 | 163,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 379,000.00 | 163,900.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 12,610,103.82 | 8,972,317.37 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,006,603.82 | 5,500,417.37 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 805,500.00 | 805,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 200,000.00 | 200,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,280,000.00 | 1,280,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,318,000.00 | 1,186,400.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 155,337,047.21 | 168,796,425.83 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,644,600.00 | 118,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 369,000.00 | 172,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 153,323,447.21 | 168,506,025.83 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 45,666,339.33 | 23,207,552.91 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 14,725,200.00 | 12,658,800.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 14,725,200.00 | 12,658,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 26,245,100.00 | 945,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 26,245,100.00 | 945,200.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,583,039.33 | 603,552.91 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,583,039.33 | 603,552.91 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 3,113,000.00 | 9,000,000.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,113,000.00 | 9,000,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | (59,895,897.56) | (48,400,318.82) |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | 10,032,000.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | | 10,032,000.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | - | (10,032,000.00) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | (59,895,897.56) | (58,432,318.82) |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

### ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,375,985,407.34 | 1,898,752,874.85 | 1,031,371,489.96 | 4,306,109,772.15 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,375,985,407.34 | 1,898,752,874.85 | 1,031,371,489.96 | 4,306,109,772.15 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | -59,895,897.56 | -59,895,897.56 |
| C08 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,375,985,407.34 | 1,898,752,874.85 | 971,475,592.40 | 4,246,213,874.59 |
| D01 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,375,985,407.34 | 1,898,752,874.85 | 911,579,694.84 | 4,246,213,874.59 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,375,985,407.34 | 1,898,752,874.85 | 971,475,592.40 | 4,246,213,874.59 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | -58,432,318.82 | -58,432,318.82 |
| D09 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,375,985,407.34 | 1,898,752,874.85 | 913,043,273.58 | 4,187,781,555.77 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

### МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,750,371,831.35 | 1,703,820,320.09 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 161,243,170.68 | 112,447,570.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 161,243,170.68 | 112,447,570.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 161,243,170.68 | 112,447,570.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 161,243,170.68 | 112,447,570.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,589,128,660.67 | 1,591,372,750.09 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,382,532,660.67 | 1,359,619,847.09 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,382,532,660.67 | 1,359,619,847.09 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 206,596,000.00 | 231,752,903.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,696,000.00 | 4,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 15,000,000.00 | 18,397,503.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 187,900,000.00 | 209,355,400.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,757,030,539.65 | 1,707,653,796.79 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,757,030,539.65 | 1,707,653,796.79 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,713,857,239.65 | 1,685,049,796.79 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 940,052,800.00 | 951,092,544.65 |
| 210101 | Үндсэн цалин | 601,629,800.00 | 611,244,900.00 |
| 210102 | Нэмэгдэл | 321,507,800.00 | 331,566,444.65 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,515,200.00 | 5,065,200.00 |
| 210104 | Урамшуулал | 1,500,000.00 | 3,216,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 7,900,000.00 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 18,914,860.67 | 20,104,348.44 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,914,860.67 | 20,104,348.44 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 147,502,200.00 | 144,629,500.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 51,099,900.00 | 47,405,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 48,511,500.00 | 55,075,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 47,890,800.00 | 42,149,200.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 39,812,600.00 | 35,772,250.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 970,100.00 | 5,283,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 30,968,100.00 | 24,597,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,966,400.00 | 4,298,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,908,000.00 | 1,592,750.00 |
| 2105 | Нормативт зардал | 200,134,800.00 | 161,537,900.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 6,495,000.00 | 6,566,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 193,639,800.00 | 154,971,300.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 49,036,800.00 | 87,098,053.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,021,000.00 | 25,234,460.00 |
| 210602 | Тавилга | - | 10,782,450.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 482,000.00 | 482,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 43,533,800.00 | 50,599,143.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 379,000.00 | 163,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 379,000.00 | 163,900.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 50,915,078.98 | 29,107,580.70 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 47,311,578.98 | 25,635,680.70 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 805,500.00 | 805,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 200,000.00 | 200,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,280,000.00 | 1,280,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,318,000.00 | 1,186,400.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 267,109,100.00 | 255,543,720.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 266,740,100.00 | 255,223,920.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 369,000.00 | 319,800.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 43,173,300.00 | 22,604,000.00 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 14,725,200.00 | 12,658,800.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 14,725,200.00 | 12,658,800.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 25,335,100.00 | 945,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 25,335,100.00 | 945,200.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 3,113,000.00 | 9,000,000.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,113,000.00 | 9,000,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | (6,658,708.30) | (3,833,476.70) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | (6,658,708.30) | (3,833,476.70) |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 11,484,855.31 | 4,826,147.01 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 4,826,147.01 | 992,670.31 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

### ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,482,579,600.00 | 1,698,653,796.79 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,482,579,600.00 | 1,698,653,796.79 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,468,975,600.00 | 1,685,049,796.79 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 951,951,200.00 | 951,092,544.65 |
| 210101 | Үндсэн цалин | 611,244,900.00 | 611,244,900.00 |
| 210102 | Нэмэгдэл | 332,425,100.00 | 331,566,444.65 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,065,200.00 | 5,065,200.00 |
| 210104 | Урамшуулал | 3,216,000.00 | 3,216,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 20,707,900.00 | 20,104,348.44 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,707,900.00 | 20,104,348.44 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 144,629,500.00 | 144,629,500.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 47,405,300.00 | 47,405,300.00 |
| 210302 | Түлш, халаалт | 55,075,000.00 | 55,075,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 42,149,200.00 | 42,149,200.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 35,854,900.00 | 35,772,250.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,472,200.00 | 5,283,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 24,597,700.00 | 24,597,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,298,000.00 | 4,298,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,487,000.00 | 1,592,750.00 |
| 2105 | Нормативт зардал | 161,537,900.00 | 161,537,900.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 6,566,600.00 | 6,566,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 154,971,300.00 | 154,971,300.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 67,250,100.00 | 87,098,053.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 23,723,500.00 | 25,234,460.00 |
| 210602 | Тавилга | - | 10,782,450.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 482,000.00 | 482,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 43,044,600.00 | 50,599,143.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 663,900.00 | 163,900.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 663,900.00 | 163,900.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 20,227,800.00 | 29,107,580.70 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 16,755,900.00 | 25,635,680.70 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 805,500.00 | 805,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 200,000.00 | 200,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,280,000.00 | 1,280,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,186,400.00 | 1,186,400.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 66,152,400.00 | 255,543,720.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 65,832,600.00 | 255,223,920.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 319,800.00 | 319,800.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 13,604,000.00 | 13,604,000.00 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 12,658,800.00 | 12,658,800.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 12,658,800.00 | 12,658,800.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 945,200.00 | 945,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 945,200.00 | 945,200.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,482,579,600.00 | 1,473,274,522.91 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,360,223,400.00 | 1,360,826,952.91 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,360,223,400.00 | 1,360,826,952.91 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 122,356,200.00 | 112,447,570.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 122,356,200.00 | 112,447,570.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 4,826,147.01 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 992,670.31 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 192,900,000.00 | 231,752,903.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 192,900,000.00 | 231,752,903.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 192,900,000.00 | 231,752,903.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 1,811,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | - | 1,811,600.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,240,100.00 | 25,850,903.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 7,510,960.00 |
| 210602 | Тавилга | - | 10,782,450.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,240,100.00 | 7,557,493.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 5,810,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 5,810,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 190,659,900.00 | 198,280,400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 190,659,900.00 | 198,280,400.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 206,596,000.00 | 231,752,903.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 206,596,000.00 | 231,752,903.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,696,000.00 | 4,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 15,000,000.00 | 18,397,503.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 187,900,000.00 | 209,355,400.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 4,826,147.01 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 992,670.31 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Азжаргал гүйцэтгэж хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 02/103 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь Эрүүгийн болон иргэний чиглэлээр гарсан Шүүхийн шийдвэрийг нэг бүрчлэн гүйцэтгэх үйл ажиллагаа явуулдаг, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий газрын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Тус байгууллагад дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв болох 1,482,579.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 14,825.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 10,378.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад өөрчлөөгүй болно.

### 33.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын  2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 91,634.7 мянган төгрөгөөр буюу 2.15 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 4,826.1 | 992.6 | -3,833.5 |
| Авлага | 8.4 | 132,750.0 | 132,758.4 |
| Бараа материал | 122,646.3 | 137,402.9 | 14,756.6 |
| Үндсэн хөрөнгө | 4,123,558.7 | 4,071,528.6 | -52,030.1 |
| **Нийт хөрөнгө** | **4,251,039.5** | **4,342,674.2** | **91,634.7** |
| Өр төлбөр | 4,825.6 | 154,892.7 | 150,067.1 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 4,246,213.8 | 4,187,781.6 | -58,432.3 |

| | | | |
|---|---|---|---|
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **4,251,039.5** | **4,342,674.2** | **91,634.7** |

Бараа материалын данс 137,402.9 мянган төгрөг болж 14,756.6 мянган төгрөгөөр өссөн нь хүнсний материалын дансны үлдэгдэл ихэсснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,071,528.6 мянган төгрөг болж 52,030.1 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас үүссэн.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,187,781.6 мянган төгрөг болж 58,432.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсанаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 18,580.1 мянган төгрөгөөр буюу 6.3 хувиар, нийт зардал өмнөх оноос 6,873.8 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар тус тус өссөн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн А/211 дугаар “2021 оны төсвийн төлөвлөгөө батлах тухай” тушаалын дагуу туслах үйл ажиллагааны орлогоос нийт 127,356.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 112,447.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн бөгөөд 14,908.6 мянган төгрөгөөр орлого тасарсан. Энэ нь COVID-19 цар тахалтай холбоотойгоор үүссэн байна.

Авлага 132,750.0 мянган төгрөг болж нэмэгдсэн нь “Шинэ гантиг” ХХК-д баяжмалын уутны бэлдмэл худалдан авах зорилгоор 132,750.0 мянган төгрөгийг шилжүүлсэнээс үүссэн байна. Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай 2021 оны 06 дугаар сарын 30-ний өдрийн 2021/14-11-0431 дугаартай баяжмалын уут нийлүүлэх гэрээ байгуулан урьдчилгаа төлбөр 30 хувь буюу 153,900.0 мянган төгрөгийг авч баяжмалын уутны бэлдмэл худалдан авах зорилгоор “Шинэ гантиг” ХХК руу 132,750.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч шинэ төрлийн ковид-19 өвчний улмаас хөл хорио тогтоож БНХАУ-ийн хил хаагдсанаас баяжмалын уутны бэлдэц авах боломжгүй байгаа нь баримтаар батлагдаж байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,360,223.4 мянган төгрөгөөр төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,360,223.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, ангийн дотоод орлогоос 122,356.2 мянган төгрөг, төвлөрүүлэхээр төлөвлөж, улсын төсвөөс 1,360,223.6 мянган төгрөг, ангийн дотоод орлогоор 95,987.1 мянган төгрөгийн орлого олж ангийн урсгал зардалд нийт 1,482,579.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,360,223.4 мянган төгрөг буюу цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардалд 951,092.5 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн

даатгалын шимтгэлд 20,104.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 144,529.5 мянган төгрөг, хангамжийн материалд 33,960.6 мянган төгрөг, нормативт зардалд 161,537.9 мянган төгрөг, эд хогшил урсгал засварт 61,247.2 мянган төгрөг, томилолт зочны зардалд 163.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 12,003.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 57,263.3 мянган төгрөг зарцуулсан ба цалин хөлс нийгийн даатгалын зардалд дутуу зарцуулсан 603.5 мянган төгрөгийг дээд газарт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Энэ үүргийн хүрээнд нийт 3 удаагийн санхүүжилтыг нэмэлт орлогын дансанд авсан.

1. Тус байгууллага нь Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банкнаас хамтран хэрэгжүүлж буй “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд зан үйлд нөлөөлөх, хөдөлмөрийн дадал олгох албадан сургалт явуулах зориулалтаар тус албаны конторын 2 давхарт 50 м2 хурлын зааланд 17,135.4 мянган төгрөгөөр иж бүрэн засвар, тохижилтын ажлыг хийсэн.
2. Өршөөлийн тухай хуулийн хэрэгжлтийг хангах зорилгоор ШШГЕГ-аас 1,262.1 мянган төгрөгийг бичиг хэрэг, түлш шатах тослох материалын зардал зарцуулсан.
3. Хорих ангийн дотоод үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хоригдолд хөдөлмөрийн чиг баримжаа олгох, цалинтай ажлын байраар хангах нийгэм, иргэдэд учруулсан гэм хорыг нөхөн төлүүлэх зорилгоор “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай 2021 оны 03 дугаар сарын 21 ны өдрийн 0117 тоот модон поддон нийлүүлэх 70,000.0 төгрөгийн үнийн дүн бүхий гэрээ, 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 2021/14-11-0431 тоот баяжмалын уут оёж нийлүүлэх гэрээний дагуу урьдчилгаа болох 153,900.0 мянган төгрөгийг нэмэлт орлогын дансаар авч баяжмалын уутны бэлдэц нийлүүлэх компанид шилжүүлсэн байна.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

## 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

## 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай. Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулж, хуулийн хугацаанд мэдээлсэн бөгөөд 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин зарлагын гүйлгээ хийхдээ цахим төлбөрийн е-баримтгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", ТБОНӨХБАҮХАТ хуулийн 19.2-д “тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана”, 47.7-д “үнэлгээний хорооноос гаргасан шийдвэр /цаашид “үнэлгээний дүгнэлт” гэх/ нь хурлын тэмдэглэл хэлбэртэй байх бөгөөд хорооны гишүүдийн олонхи дэмжиж гаргасан шийдвэр, түүний үндэслэл, холбогдох бүх мэдээллийг агуулсан байна”, 14.1-д “дараахь нөхцөл байдал тогтоогдвол тендерт оролцогч ерөнхий нөхцөл хангаагүй гэж үзнэ” хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 9,814.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | Биелэлт | Зөрүү |
|---|---|---|---|

| Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | хувь |
| Зөвлөмж | 2 | 9,814.7 | 2 | 9,814.7 | 0 | 0 | 0 |
| Нийт дүн | 2 | 9,814.7 | 2 | 9,814.7 | 0 | 0 | 0 |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 256,974.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 255,105.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,704.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж, 163.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 төлбөрийн акт өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Зардлын зүйл ангийг буруу сонгосоноор санхүүгийн үр дүнгийн тайланд 255,105.9 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлсэнийг залруулав.

### 4.2 Төлбөрийн акт

Томилолтын зардал олгохдоо анхан шатны баримтгүй, албан томилолт хаагаагүй 163.9 мянган төгрөгийг олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт тогтоов

**4.3 Албан шаардлага** Байхгүй.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал***

***<u>1.1 Илрүүлэлт:</u>***

Зарлагын гүйлгээ хийхдээ анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй 1,704.9 мянган төгрөгийн дутуу баримтаар гүйлгээ хийсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*<u>1.2</u> <u>Өгсөн зөвлөмж</u>:*

Батлагдсан төсвийн зарцуулалтад үр дүнтэй хяналт хэрэгжүүлж, бараа материалын бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй баримтаар гүйлгээ хийхгүй байх.

***1.3 Илрүүлэлт:***

Худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа техникийн тодорхойлолт байхгүй, хурлын тэмдэглэлийн шийдвэр тодорхойгүй хэзээ хэрхэн зарлах, нээх, хэн хэдэн төгрөгөөр хэдий хугацаанд гүйцэтгэх нь тодорхойгүй, хувилбарт тендер хүлээн зөвшөөрөхгүй гэсэн боловч санал болгосон үнийг өөрчлөн хувилбарт тендерийг хүлээн зөвшөөрсөн, ҮХГ-ийн мэдүүлгийн огноо засвартай, гэрээ байгуулах эрх олгосон албан бичигт гэрээний үнэ болон хугацаа тодорхой бус ТОӨЗ 1.1 шаардсан баримт бичгүүд нь хоорондоо зөрүүтэй байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 19.2-д "тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана", 47.7-д "үнэлгээний хорооноос гаргасан шийдвэр /цаашид "үнэлгээний дүгнэлт" гэх/ нь хурлын тэмдэглэл хэлбэртэй байх бөгөөд хорооны гишүүдийн олонхи дэмжиж гаргасан шийдвэр, түүний үндэслэл, холбогдох бүх мэдээллийг агуулсан байна", 14.1-д "дараахь нөхцөл байдал тогтоогдвол тендерт оролцогч ерөнхий нөхцөл хангаагүй гэж үзнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*1.4 Өгсөн зөвлөмж:*

Худалдан авах ажиллагааг ил тод, үр ашигтай, хариуцлагатай зохион байгуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар | 4 | 256,974.9 | 1 | 255,105.9 | 1 | 163.9 | | | 2 | 1,704.9 |

**ОРХОН АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# АКТ

2022 оны 02 сарын 27 өдөр | Дугаар 03/09 ОРА-2022/19/НА-СТА-ТШЗ | Эрдэнэт хот

## ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

163900 төгрөгийн албан томилолтын зардал олгохдоо томилолт хаагаагүй, анхан шатны баримтгүй олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", НББ-ийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.5-д “бүртгэл тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Анхан шатны баримтгүй олгосон 163900 төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 тоот /Ор.Хүү торгуулийн орлого/ дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 30-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга М.Ариунболд, ерөнхий санхүүч Т.Буянболд нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:....................................Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР....................................Б.ЭРДЭНЭ

АУДИТОР....................................Б.АЗЖАРГАЛ